

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 59.080.30

Гэрийн эсгий. Техникийн шаардлага	MNS 0296 : 2008 MNS 296:83-ын оронд
Textiles. Covering Wool Felt. Technical specification	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн 23 тоот тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 2008 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

## 1 Хамрах хүрээ

Энэ стандарт нь механик аргаар үйлдвэрлэсэн гэрийн эсгийний чанарын үзүүлэлтийг тогтооход хамаарна.

## 2 Норматив ишлэл

MNS 1096:2008 Гэрийн эсгий шинжлэх арга.

## 3 Нэр томъёо, тодорхойлолт

**3.1 Зумалсан ноос (Tannery hair)** – малын арьснаас үйлдвэрлэлийн аргаар зумалж, угаасан үс, ноосыг;

**3.2 Үйлдвэрийн хаягдал (Industrial wastes)** – очёс болон тууз, цувимал, утасны үзүүрүүдийг хэлнэ.

## 4 Ангилал

4.1 Эсгийг өнгөөр нь :

- а/ бор
- б/ цагаан

4.2 Чанараар нь:

- а/ I зэрэг
- б/ II зэрэг гэж ангилна.

## 5 Техникийн шаардлага

5.1 Гэрийн эсгийг тухайн үйлдвэрлэгч байгууллагын технологийн зааврын дагуу энэ стандартын шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэнэ.

5.2 Гэрийн эсгий хийхэд орох түүхий эдийн төрөл, хэмжээ 1-р хүснэгтэд заасны дагуу байна.

1-р хүснэгт

Д/д	Ноосны нэр төрөл	Ноосны орц, %	
		бор эсгий	цагаан эсгий
1	Уртын ноос, ахар, хурганы ноос, нэхийний хяргадас	10	40
2	Хонины зумалсан ноос	40	45

**MNS 0296 : 2008**

3	Бодын хөөвөр	25	
4	Ямааны зумалсан ноос, хялгас	5	-
5	Ноос боловсруулах үйлдвэрийн хаягдал	20	15
	Дүн	100	100

ТАЙЛБАР 1: Хонины уртын ноос ба ахар, хурганы ноосыг өөр хооронд нь 100% орлуулж болно.

ТАЙЛБАР 2: Хонины зумалсан ноосыг нэхийний хяргадсаар 40% хүртэл орлуулж болно.

ТАЙЛБАР 3: Бодын хөөврийг ямааны зумалсан ноос, үйлдвэрийн хаягдал, нэхийний хяргадас, хонины зумалсан ноосоор орлуулж болно.

ТАЙЛБАР 4: Ямааны зумалсан ноосыг бодын хөөвөр, хонины завод ноосоор орлуулж болно.

**5.3** Эсгийний үндсэн хэмжээ, физик механикийн үзүүлэлт 2-р хүснэгтэд заасны дагуу байна.

2-р хүснэгт

Д/д	Үзүүлэлт, хэмжих нэгж	Хэмжээ	Зөвшөөрөгдөх зөрүү
1	Урт, м	5,2	+0,3 -0,2
2	Өргөн, м	1,8	+0,10 -0,02
3	Зузаан, мм	12,0	+2 -1
4	1м -ийн (уртааш) жин, кг	4,0	±0,2
5	1м <sup>2</sup> -ийн жин, кг	2,2	±0,1
6	Чийглэг, % ихгүй	15,0	-
7	Нягтрал, г/см <sup>3</sup>	0,17	-0,02
8	Тасрах үеийн даац, Н/см <sup>2</sup> , багагүй	130,0	-

**5.4** Эсгийний зах үндсэн хэмжээнээс ±2 см-ээс дээш хэмжээгээр долгионтсон байж болохгүй.

**5.5** Эсгийний нягтрал бүх талбайд жигд байна.

**5.6** Эсгийнд нугалаас, дэл, цоорхой байж болохгүй.

**5.7** Гэрийн эсгийг дараах байдлаар зэрэглэнэ.

#### **5.7.1 I зэрэг**

Эсгий нь стандартын шаардлага хангасан, гэмтэл согоггүй байна.

#### **5.7.2 II зэрэг**

Эсгий нь дор дурьдсан согог гэмтэлтэй байж болно.

а/ Нимгэн зузаан нь тогтоосон хэмжээнээс ±2 мм-ээр зөрөөтэй, нягтрал нь 0,02 г/см<sup>3</sup> -ээр бага;

б/ 30 см хүртэлх урттай цуурхайг 1-1,5 см-ийн алхамтайгаар эсгийний хоёр талаас цэвэр үзэмжтэй оёсон;

**5.8** Эсгийнээс бут ноосыг гараар татахад сугарахгүй барьцалдаж ширэлдсэн байна.

## **6 Шалгаж хүлээн авах**

**6.1** Гэрийн эсгийг энэ стандартын шаардлагын дагуу нэг бүрчлэн шалгаж хүлээж авна.

**6.2** Гэрийн эсгийний чанарын талаар гарсан маргааныг итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн шийдвэрлэнэ.

## **7 Баглах, хаяглах, хадгалах, тээвэрлэх**

**7.1** Эсгийний нэг үзүүрээс 50 см-ээс дотогш зайд зэрэг дугаар, уртын хэмжээг арилахгүй будгаар бичиж, энэ хаягийг гадна үзүүрийн дотор талд оруулан эсгийг нэг бүрчлэн хуйлна.

**7.2** Эсгийг 20 см-ээс доошгүй өндөр тавиур дээр ус, чийгээс хамгаалж 2 м-ээс өндөргүйгээр давхарлан хураана.

**7.3** Эсгийг ус чийгээс хамгаалж бүтээлэгтэй тээвэрлэнэ.

**ТӨГСӨВ.**